



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/383

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд боловсрол, соёл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улсын чанартай олимпиад уралдаан, тэмцээнд амжилт гаргасан сурагчид, бэлтгэсэн багш нарыг урамшуулсугай.

2. Шаардагдах 296,998,330 (Хоёр зуун ерэн зургаан сая есөн зуун ерэн найман мянга гурван зуун гуч) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

